



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН
ДООД ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1.Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг 1 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг 2 дугаар хавсралт, Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээг 3 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн тогтоосугай.
- 2.Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг 2026 оны батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, холбогдох сайд нарт даалгасугай.
- 3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг 6 дугаар хавсралт," гэснийг, "Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "эрүүл мэнд," гэснийг, мөн заалтын "Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн," гэснийг, мөн тогтоолын 2 дахь заалтын "Эрүүл мэнд," гэснийг тус тус хассугай.
- 4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
- 5.Энэ тогтоолыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.УЧРАЛ

ГЭР БУЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР